



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 773

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. Авлигатай тэмцэх газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 05/21314 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар О.Батчулууныг холбогдох хууль тогтоомжийн дагуу түр томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан зохих журмын дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ